Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022.12.15

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /сая төгрөг / | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Байгаль орчин, аялал жуулчлалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, бодлого боловсруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглуулах, нөхөн сэргээх, байгаль орчны мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлал ногоон хөгжлийг дэлгэрүүлэх, салбарын чиг үүрэг бүхий байгууллагуудыг удирдлага арга зүйгээр хангахад эрхэм зорилго оршино. | | | | | | | |
| **1.** | **Зорилго:1** Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьчилан сэргийлэх, байгаль хамгаалах хууль тогтоомж, журмуудыг өрд иргэдэд сурталчлах гарсан зөрчлийг цаг тухайд нь таслан зогсоох ажлуудыг жилийн ажлын төлөвлөгөөнд тусганы дагуу, хөдөө сумдад дэс дараатай зохион байгуулж, гарсан хэрэг зөрчлийг орон нутгийн радио, хэвлэл мэдээллээр сурталчлах ажлыг сар бүр зохион байгуулна. | | | | | | |
| 1.1 | Байгаль орчны эсрэг гэмт хэргийн зөрчлийг бууруулах зорилгоор байгаль орчны салбар болон хууль хяналтын байгууллагуудыг нэгдсэн хяналт шалгалтыг хийх нөхцөлөөр хангах. */хууль бус мод бэлтгэл, хууль бусаар ашигт малтмал ашиглах, хулгайн ан, зохисгүй газар ашиглалт, эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, мөн ойн нөхөн сэргээлт, хог хаягдал зөрчил гэх мэт бүх чиглэлээр/* | 2.0 | Байгаль орчны эсрэг гэмт хэргийн зөрчлийг бууруулах зорилгоор байгаль орчны салбар болон хууль хяналтын байгууллагуудыг нэгдсэн хяналт шалгалтыг хийх эсэх | 2021 онд Байгаль орчны эсрэг гэмт хэргийн зөрчлийг бууруулах зорилгоор байгаль орчны салбар болон хууль хяналтын байгууллагууды г нэгдсэн хяналт шалгалтыг 8 удаа зохион байгуулсан | Байгаль орчныг хамгаалах тухай багц хууль тогтоомжийг 16 удаа сурталчилсан байна. | Байгаль орчны эсрэг гэмт хэргийн зөрчлийг бууруулах зорилгоор байгаль орчны салбар болон хууль хяналтын байгууллагуудтай хамтран нэгдсэн хяналт шалгалтыг 6 удаа ажлын удирдамжийн дагуу зохион байгууллаа. Үүнд:<br>Ховд голын сав газрын дагуух, Алтанцөгц, Бугат, Ногооннуур сумуудын ойн сан бүхий газруудад хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гаргахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах, хяналт шалгалтын ажлыг тус тус хийж гүйцэтгэв.<br>Хууль бус түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтыг таслан зогсоох ажлын хүрээнд аймгийн МХГ,ЦГазартай хамтарсан сарын аяныг зохион байгуулж аяны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хугацаанд хууль бус хайраг олборлосон 5 иргэнийг илрүүлж хууль хяналтын байгууллагад шилжүүлэв. | |
| 1.2 | Байгаль хамгаалагч, байгалийн баялаг нөөц хамгаалах нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг чадавхжуулах сургалт зохион байгуулах | 3.0 | үйл ажиллагааг чадавхжуулах сургалт зохион байгуулах эсэх | Сумдын байгаль хамгаалагч нарыг чадавхжуулах сургалтыг 2 удаа зохион байгуулсан | 26 байгаль хамгаалагч, 47 байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн төлөөлөл оролцоно. | Байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагч, амьтан хамгаалах 10 гаруй, ойн нөөц хамгаалах 10 гаруй нөхөрлөлүүдийн ахлагч нарын үйл ажиллагааг чадавхжуулах сургалтыг сумуудад зохион байгуулж, гарын авлагаар хангаж ажиллав. | 95 % |
| 1.3 | Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг гаргаж аймгийн ЗДТГазрын ХОХБТХ хүргүүлэх | | Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах эсэх | Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавьж хөтөлбөрүүдийн биелэлтийг БОАЖЯам, аймгийн ЗДТГазрын ХОХБТХ-д хүргүүлсэн байна. | Хууль тогтоомж, төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт хангагдаж үр дүнг тогтоосон хугацаанд нь аймгийн ЗДТГазрын ХОХБТХ-д хүргүүлсэн байна. | Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж аймгийн ЗДТГазрын ХОХБТХэлтэст цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллав. | 100 % |
| 1.4 | Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн үндсэн чиглэл төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж биелэлтийг аймгийн ЗДТГ-т хүргүүлэх | | Үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах эсэх | Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн үндсэн чиглэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж аймгийн ЗДТГазарт хүргүүлэв. | Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн үндсэн чиглэл төлөвлөгөөнд тусгагдсан 2023 онд хийж гүйцэтгэх арга хэмжээний ажлыг зохион байгуулсан байна. | Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөний 2022оны биелэлт, аймгийн хөгжлийн жилийн үндсэн чиглэл төлөвлөгөөний тус газарт хамаарал бүхий хэсгийн заалтуудыг тус бүрээр хэрэгжилтийн биелэлтийг гаргаж аймгийн ЗДТГ-т хугацаанд хүргүүлэв. | 95 % |
| 1.5 | Үндэсний аюулгүй байдлын аймгийн орон тооны бус салбар зөвлөлийг | | Үндэсний аюулгүй байдлыг мэдээ мэдээлэлээр | ҮАБ-ын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах ажлын | Үндэсний аюулгүй байдлын аймгийн орон тооны бус салбар | Үндэсний аюулгүй байдлын аймгийн орон тооны бус салбар зөвлөлийг мэдээ, мэдээллээр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээ, мэдээлэлээр хангах ажлыг хариуцан хийж гүйцэтгэх | | хангах ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулан ажиллах эсэх | хүрээнд тус байгууллагатай холбоотой мэдээ, мэдээллийг өдөр бүр аймгийн Цэргийн штабын /70423820/ утсанд мэдээллэж, хагас, бүтэн жилийн тайланг Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтэст хүргүүлэн ажиллав. | зөвлөлийг мэдээллээр хангаж, өгсөн үүрэг даалгаврын биелэлт, тайланг хугацаанд нь хүргүүлнэ | хангах ажлын хүрээнд тус байгууллагатай холбоотой мэдээ, мэдээллийг нэгтгэн ажлын таван өдөрт $16^{00}$-$17^{00}$ цагийн хооронд аймгийн Цэргийн штабын /70423820/ утсанд мэдээлэл өгч, бүтэн жилийн тайланг Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтэст бичгээр болон и-майлаар хүргүүлэн ажиллав. | |
| 1.6 | Аймгийн Засаг дарга БОАЖСайдтай 2022 онд хамтран ажиллах гэрээний биелэлтийн хэрэгжилтийг хангах ажиллах | | Гэрээний биелэлтийг хангах эсэх | 2021 онд Аймгийн Засаг дарга БОАЖСайдтай 2021 онд хамтран ажиллах гэрээний биелэлтийг гаргаж БОАЖЯ, аймгийн ЗДТГазарт хүргүүлэв. | Аймгийн Засаг дарга БОАЖСайдтай 2022 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан ажлуудын биелэлтийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан байна | Аймгийн Засаг дарга БОАЖСайдтай 2022 онд хамтран ажиллах гэрээний биелэлтийг ЗДТГазрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс, ХБТХОХэлтэст хянуулан 95.1 хувьтай дүгнүүлж, БОАЖЯамд цахимаар болон бичгээр хүргүүлэв. | 95,1 % |
| **2.** | **Зорилго:2** Ан амьтан байгалийн ургамлын нөөц, тархалтыг тогтоох, ашиглалтыг зохицуулах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, байгаль орчны цахим мэдээллийн системийн хэвийн ажиллагааг хангах. | | | | | | |
| 2.1 | Биотехникийн арга хэмжээ авах ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх | 8.0 | Ан амьтны амьдрах орчныг сайжруулах эсэх | 7 агнуурын бүс нутаг болон менежментийг хариуцагч компаниудтай хамтран ангийн өвөлжилт хүндэрсэн бүс нутгуудад биотехникийн арга хэмжээ авах ажлыг зохион байгуулсан. | Нэн ховор, ховор амьтны өвөлжилтийн байдал хүндэрсэн 8 бүс нутагт биотехникийн арга хэмжээ авах ажлыг зохион байгуулсан байна | БОАЖСайд аймгийн Засаг даргатай хамтран ажиллах 2022 оны №22-02 тоот гэрээний хүрээнд Ногооннуур сумын “Бахлаг”, “Модон овоо”, Бугат сумын “Тошинт”,”Хөшөөт уул”, Сагсай “Түргэн”, Толбо сумын “Хотожон”, “Бургаст”, Улаанхус сумын “Хар уул”, Цэнгэл сумын “Мөст булаг”,агнуурын ангийн бүс нутгуудад ховор амьтад зориулан давс тавих биотехникийн арга хэмжээ авах ажлыг аймгийн МХГазартай хамтран зохион байгуулалаа. | 100 % |
| 2.2 | Хугацаа дууссан болон шинээр хийлгэх | | Менежментийн төлөвлөгөө батлуулах эсэх | 6 агнуурын бүс нутгуудад Нарийвчилсан | Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг | Хэрэгжилтийн хугацаа дууссан Ногооннуур сумын | 95 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нарийвчилсан агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, агнуурын менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хангуулах | | | агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг ан амьтны мэргэжлийн байгууллагаар хийгүүлсэн. | хангуулж, хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг зохион байгуулсан байна | “Бахлаг”АБНутагт Агнуурын зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг ”Анчдын нийгэмлэг” ТББ, “Модон овоо”, “Бураат” Агнуурын бүс нутгуудад Агнуурын зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг “Агнуурын менежментийн Тэх төв” ТББ, Булган сумын “Улаагчин”, “Рашаант-Ендэрт” Алтай сумын “Халуун бардам шар говь” агнуурын бүс нутгуудын Агнуурын зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг “Агнуур судлалын нийгэмлэг”ТББ, Ногооннуур сумын “Харлаг” агнуурын бүс нутгийн Агнуурын зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг “Авралын эрэлд” ХХК-аар тухайн агнуурын бүс нутгуудын менежментийн хариуцагч компануудын санхүүжилтээр хийлгэх ажлыг зохион байгууллаа. Аймгийн хэмжээний 26 агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. | |
| 2.3 | Жил бүр тусгай болон ахуйн, үйлдвэрлэлийн зориулалтаар агнах, барих амьтан ургамлын захиалгыг холбогдох газарт хүргүүлэх | | БОАЖСайдын тушаал, аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангуулах эсэх | 2022 оны агнах барих, ахуйн, үйлдвэрлэлийн тусгай зориултаар ан амьтны саналыг хугацаанд БОАЖЯаманд хүргүүлж, нөөц ашигласаны төлбөрийн оролгод хяналт тавьж, тайланг | 2023 онд тусгай, ахуйн, үйлдвэрлэлийн зориулалтаар агнах барих ан амьтны саналыг БОАЖЯаманд хүргүүлж, батлуулах ажлыг зохион байгуулсан байна | Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1 дэх заалтын дагуу хугацаанд аймгийн хэмжээний агнуурын бүс нутгуудаас тусгай, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар 2023 онд агнах барих ан амьтны саналыг БОАЖЯамны Хүрээлэн буй орчин, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | БОАЖЯаманд хүргүүлсэн | | байгалийн нөөцийн удирдлагын газарт хүргүүлэв. | |
| 2.4 | Аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллахад гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах | 40.0 | Аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөө батлуулах эсэх | Ерөнхий агнуур зохион байгуулалт, агнуурын менежментийн төлөвлөгөөний хугацаа дууссан | 2022 онд агнуурын менежментийн төлөвлөгөөг шинээр хийлгэж батлуулах ажлыг зохион байгуулсан байна | Тендерт шалгарсан “Агнуур судлалын нийгэмлэг” ТББайгуулага аймгийн Засаг даргын тамгын газарт гэрээ байгуулж, гэрээний дагуу судалгааны ажлыг хийж гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 70%-тай байна. | 90 % |
| 2.5 | Цахим мэдээллийн санг тогтмол баяжуулах | | БОХА-1-10 хүртэлх статистик мэдээллийг сум тус бүрээр оруулах эсэх | 2021 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэдээллийн санд сумдын захиргааны БОХА-1-10 хүртэлх статистик мэдээллийг нэгтгэж сум тус бүрээр оруулав | БОАЖЯамны статистик мэдээллийн санд мэдээллийг маягтын дагуу үнэн зөв оруулах ажлыг зохион байгуулсан байна | 2022 оны БОХ-1-10 маятуудыг сум дундын ойн анги болон сумдын байгаль хамгаалагч нараас сум тус бүрээр нэгтгэн хугацаанд оруулан ажиллаж байна. | 100 % |
| 2.6 | Байгалийн нөөцийг хамгаалах ажлын хүрээнд Чигэртэйн голын ай савын БЦГ-ын тодорхой цэгүүдэд ан амьтны тооллогыг 2 удаа зохион байгуулж (төллөх үе, орооны үе) Биотехникийн арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах | 2.0 | Биотехникийн арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх эсэх | 2021 онд Чигэртэйн голын ай савын БЦГ-уудад 1 сая төгрөгөөр биотехнийкийн арга хэмжээг авах ажлыг Чигэртэйн голын ай савын БЦГын хамгаалалтын захиргаатай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн | Чигэртэйн голын ай савын БЦГ-уудад биотехникийн арга хэмжээг авах ажлыг зохион байгуулсан байна | Монгол Улсын Амьтны тухай хуулийн 6 зүйлийн 6.1.8 заалт, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 30 зүйлийн 4-т заалт, Хамгаалалтын захиргааны даргаар батлуулсан удирдамж, мөн мэргэжилтэн, байгаль хамгаалагч нарын судалгааг үндэслэн хамгаалалтын захиргаанаас ан амьтдад зориулан 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр хүртэл Чигэртэйн голын ай савын БЦГ-т нийт 3 цэгт 3 удаа Биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүллээ.<br><br>1. 2022.01.26-ны өдөр – Чигэртэйн голын ай савын БЦГ-ын Бураат уулын Шар жалга | 100 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэдэг газарт /Халиун буга/<br>2. 2022.02.09-ны өдөр - Чигэртэйн голын ай савын БЦГ-ын Бураат уулын Шар жалга гэдэг газарт /Халиун буга/<br>3. 2022.03.26-ны өдөр - Чигэртэйн голын ай савын БЦГ-ын Үеэрт гэдэг<br>газарт /Аргаль хонь/ | |
| **3.** | **Зорилго:3** Усны нөөцийг хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах | | | | | | |
| 3.1 | Усны тухай хуулийн 28.4-т заасны дагуу иргэн аж ахуйн нэгж байгууллагуудаас ирсэн хүсэлтийн дагуу ус ашиглуулах дүгнэлт гаргаж ажиллах | | Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах эсэх | 10 газарт ус ашиглуулах дүгнэлт гаргасан | 10 аас доошгүй иргэн аж ахуйн нэгжид ус ашиглуулах дүгнэлт гаргаж ажиллах | Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 4 дэх заалтад заасны дагуу Дэлүүн, Улаанхус, Толбо, Буянт сумуудын аж ахуйн нэгж байгууллагуудыг дулаанаар хангаж үйл ажиллагаа явуулдаг Жанат” ХХК, “Агайын ХХК, “Ахбейл ХХК, Өлгий сумын 3,9,13 багуудад ард иргэдэд үйлчилгээ үзүүлж үйл ажиллагаа явуулдаг “Жадыра”, “Гүлим”, “Жайнаш”, “Жорга” халуун усны газрууд, Толбо, Цэнгэл, Буянт сумуудад улаан тоосго болон стандарт блок үйлдвэрлэж үйл ажиллагаа явуулдаг Толбожай ХХК, Цэнгэл тоосго ХХК, Тэнэгэр алтан тоосго, иргэн Тауке, Бөртеш хоршоо, Өлгий сумын 9-р багт үйл ажиллагаа явуулдаг Bentley авто угаалга, Алтанцөгц, Ногооннуур сумуудад эрэл хайгуул явуулж ажилласан “Монголын алт МАК ХХК, Өнгөд маргад ХХКомпаниудын 2022 онд ус ашиглуулах дүгнэлтүүдийг гаргаж ажиллав. | 100 |
| 3.2 | Хар нуур Ховд голын сав газрын захиргааны гаргасан | | Ус ашиглалтын талаар хууль журмыг хэрэгжүүлэх | 9 газарт зөвшөөрөл олгож гэрээ байгуулж ажилласан | 8-10 газар зөвшөөрөл олгож гэрээ байгуулж | Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 6 дахь заалтад заасны дагуу Хар нуур – Ховд | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дүгнэлтийг үндэслээн ус ашиглах зөвшөөрөл олгож, ус ашиглах гэрээ байгуулж ажиллах | | ажиллах эсэх | | ажиллаж, биелэлтэнд хяналт тавьж ажиллана | голын сав газрын захиргаанаас гаргасан ус ашиглуулах дүгнэлтүүдийг үндэслэн дараах аж ахуйн нэгжүүдэд ус ашиглах зөвшөөрөл олгож усны нөөц ашиглах гэрээ байгуулан усны нөөц ашигласны төлбөр ноогдуулж ажилласан. Үүнд:Гранд рөүд ХХК, Эрчим Баян –Өлгий ХК, Эйш кей би интернешнл холдинг ХХК, Өлгий Толбо тур ХК, Дөрвөн бэрх жуулчны бааз Жол ХХК, Нью констракшн ХХК, Азат ХХК, Лунзян роуд ХХК, Угур ХХК, | |
| 3.3 | Аймгийн хэмжээний гадаргын усны тооллого явуулах ажлыг зохион байгуулах | | Усны тухай хуулийн хэрэгжилт хангах эсэх | 1 удаа тоо бүртгэлийн ажил хийгдсэн , | Тооллогын ажлыг зохион байгуулсан байна | 2022 онд гол горхи - 409, булаг шанд - 943, нуур тойром - 1243, рашаан- 32, услалтын систем - 16, цэвэрлэх байгууламж - 1 , гүний худаг - 590, гар худаг - 6019, ширгэсэн гол горхи - 9, булаг шанд - 18, нуур тойром – 6 тус тус тоологдсон. | 100 |
| 3.4 | Булаг шандын эхийг хамгаалалтанд авч тохижуулах ажлыг зохион байгуулах | 9.0 | Усны зүй зохистой ашиглалт бий болгох эсэх | Толбо, Булган, Дэлүүн сумдад тус бүрт 1 ширхэг булгийг хамгаалагдсан | Алтанцөгц, Баяннуур, Ногооннуур сумдад булаг шандын эх хамгаалагдсан байна | 2022 онд Баяннуур сумын 3-р багийн нутагт байрлах “Уст рашаан” булаг, Ногооннуур сумын “Хавцлын булаг, Алтанцөгц сумын 1-р багийн нутагт “Чихтэйн булаг”-уудын эхийг хамгаалах, ундраг урсцыг сайжруулах ажлыг “Нурбах” ХХК хийж гүйцэтгэж орон нутагт хүлээлгэж өгсөн. | 100 |
| 3.5 | Өлгий сумын төвийн орон сууцанд амьдардаг ард иргэдийг цэвэр усаар хангагч НААҮ-ний Суат ХХК –ны Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн | | Эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж ажилласан эсэх | 4 удаа мөрдүүлж ажилласан | Улиралд 1 удаа цэвэрлэгээ хийлгүүлж ажиллах | Суат ХХК-ны Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэх зорилгоор 4 удаа цэвэрлэгээний ажлыг хийлгүүлэх ажлыг зохион байгуулав. | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дэглэмийг мөрдүүлэх | | | | | | |
| 3.6 | Аймгийн төвийн үйл ажиллагаа явуулдаг тоолуургүй аж ахуй нэгж, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах ажлыг зохион байгуулах | | Тоолууржуулалтын ажлыг зохион байгуулсан эсэх | 2021 онд нийт 85 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тоолуур суурилуулах ажлыг зохион байгуулж ажилласан. | Ус ашиглагч иргэн аж ахуйн нэгж төсөвт байгууллагууд тоолуур суурилуулах ажлыг зохион байгуулсан байна. | Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглуулах зорилгоор аймгийн Засаг даргын 2022 оны 3 дугаар сарын 16-ний өдрийн А/176 тоот захирамж гаргуулж хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн тоолуургүй аж ахуйн нэгж байгууллагуудыг тоолууржуулах шаардлага тавьж ажилласан. 2022 оны бүтэн жилийн байдлаар дараах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тоолуур суурилуулах ажил хийгдсэн.<br>Үүнд: 22 аж ахуйн нэгж, 53 айл өрхөд тоолуур суурилуулсан. | 85 |
| **4.** | **Зорилго:4** Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа, үйлдвэрлэл явуулдаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг БОНБЕҮнэлгээнд хамааруулан, шаардлагатай аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны хамгаалах менежментийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах. | | | | | | |
| 4.1 | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг БОНБҮнэлгээнд хамруулах | | Байгууллага, аж ахуйн нэгжүүд БОНБҮнэлгээнд хамааруулах эсэх | 2021 онд нийт 233 аж ахуйн нэгжийг БОНБҮнэлгээнд хамруулсан | Хуулийн хэрэгжилт хангуулан үр дүнг тооцно | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 170 иргэн, ААН-ийн төслийн баримт бичигт БОНБЕҮ-ний дүгнэлт гаргаж мэдээлийн санд оруулан ил тоот байдлыг хангаж ажиллаж байна**.** | 100 |
| 4.2 | Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгуулагуудын тухайн онд хэрэгжүүлэх байгаль орчны хамгаалах менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах | ААНБ-ын төсөв хөрөнгөөр | Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих эсэх | 2020 онд 10 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн Байгал орчны менежментийн төлөвлөгөөнй хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан | Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт биелэгдэж үр дүнг тайлагнах | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй 22 ААНэгжийн 2022 оны БОМТ батлуулж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллав**.** | 100 |
| 4.3 | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгуулагуудын БОНБЕҮнэлгээний | | Мэдээллийн санд мэдээллийн бүрэн оруулах эсэх | 2021 онд 233 БОНБЕҮнэлгээний дүгнэлт гаргаж, БОАЖЯамны БОҮнэлгээний мэдээллийн санд бүрэн оруулсан | БОАЖЯамны БОҮнэлгээний мэдээллийн санд ААНБ-ын мэдээллийг бүрэн | 2022 оны бүтэн жилийн байдлаар 170 төсөлийн баримт бичигт БОНБЕҮнэлгээний дүгнэлт гаргаж БОАЖЯ-ны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дүгнэлтийг БОАЖЯамны БОҮнэлгээний мэдээллийн санд бүрэн оруулах | | | | оруулах ажлыг зохион байгуулсан байна | мэлээлийн санд бүрэн оруулсан. | |
| **5.** | **Зорилго:5** Орчны бохирдлын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах | | | | | | |
| 5.1 | Байгальд ээлтэй хэрэглээний соёл хэвшүүлэх, хог хаягдлыг зүй зохистой хаях, ангилах, дахин ашиглах дадал зуршлыг төлөвшүүлэх, хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хэвлэл мэдээллээр сурталчлах, ЕБСургууль, Цэцэрлэг насны хүүдүүдэд сургалт зохион байгуулах | Төсөл хөтөлбөр | Хог хаягдлыг ангилан ялгаж хаях, түүний байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учруулах хор нөлөөл, орчны бохирдлын талаар хэвлэл мэдээллээр сурталчилж, сургалт хийсэн эсэх | Холбогдох байгууллагуудтай хамтран сургалт сурталчилгааг 3 удаа зохион байгуулсан байна | Сургалт, сурталчилгааны ажил 4 удаа зохион байгуулсан байна | Холбогдох байгууллагуудтай хамтарсан удирдамжийн дагуу хог хаягдал, түүнийг ялгаж хайхын ач холбогдол болон ”Хуванцар савыг хэрэглээнээс хасъя” с эдэвт сургалт, сурталчилгааны ажлыг , Өлгий сумын 22 цэцэрлэгийн 250 багш, ажилчид болон ахлах, бэлтгэл бүлгийн 800 хүүхдэд сургалт, сурталчилгаа хийж ажиллав.<br>Насан туршийн боловсролын төвтэй хамтарсан удирдамж гаргаж Хог хаягдлын талаарх багц сургалт, “Хог хаягдал ба түүний менежмент, “Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах, хуванцар гялгар уутнаас татгалзах, дахин боловсруулахын ач тус сэдвийн хүрээнд энэ долоо хоногт Өлгий сумын бүх ЕБСургууль болон Ногооннуур, Баяннуур, Алтай, Алтанцөгц, Буянт, Толбо, Дэлүүн, Цагааннуур тосгоны ЕБСургуулиудын нийт 20 багш, 2000 гаруй сурагчдад сургалт зохион байгууллаа.<br><br>БОАЖГазар, Насан туршийн боловсролын төвтэй хамтарсан удирдамжийн дагуу “ЭХ ДЭЛХИЙГЭЭ ХАЙРЛАЯ” сэдэвт аяны хүрээнд аймгийн төвийн “Бастама”, “Дарын”, “Билге-Тегин” болон 1,2,3,4,6 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар ерөнхий боловсролын сургуулиудын эко клубийн сурагчдад сургалт зохион байгууллаа. | |
| 5.2 | Орчны бохирдлын эх үүсвэрүүдийн тооллогыг аймгийн хэмжээнд холбогдох байгууллагуудтай хамтарч зохион байгуулж БОАЖЯам болон аймгийн ЗДТГазарт хугацаанд тайлагнах | | "Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тооллогыг орон нутагт зохион байгуулах эсэх | 2021 онд аймгийн Засаг даргын А/846 дугаар захирамжийн дагуу 2020 оны Агаар, орчны бохирдлын эх үүсвэрийн тооллогыг аймгийн хэмжээнд зохион явуулж, тооллогын материалыг нэгтгэж тайлан гарган холбогдох газруудад хүргүүлсэн | Аймгийн Засаг даргын А/993 дугаар "Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого зохион байгуулах тухай" захирамжийн дагуу 2021 оны орчны бохирдлыг эх үүсвэрүүдийн тооллого зохион байгуулж, тооллогын мэдээллийг нэгтгэн боловсруулан тайланг зохих газруудад тайлагнах | Аймгийн засаг даргын "Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх" А/993 дугаар захирамжийн дагуу 2021 оны орчны бохирдлын эх үүсвэрийн тооллогыг аймгийн МХГ, УЦУОШТөвтэй хамтран зохион байгуулж тайлан мэдээг БОАЖЯ болон аймгийн ЗДТГ-т хүргүүлэв. | 100 |
| 5.3 | Олон нийтийг хамарсан их цэвэрлэгээний ажлыг сумдын ЗДТГазартай хамтаран зохион байгуулах | ОНТ төсөв | Цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсан тоо | 2 удаа нийтийг хамаарсан цэвэрлэгээний ажил хийсэн байна | Их цэвэрлэгээний ажлыг 3-аас доошгүй удаа зохион байгуулсан байна | БОАЖГ-аас Цагаан сарын баярыг тохиолдуулан "ХОГГҮЙ ЦЭВЭРХЭН ШИНЭЛЦГЭЭЕ" урианы доор сумдын ЗДТГазартай хамтран олон нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулав. Уг арга хэмжээний хүрээнд 80 гаруй аж ахуйн нэгж, албан байгууллага оролцож, хог хаягдлуудыг цэвэрлэх ажлыг зохион байгууллаа. Аймгийн бүх сумууд "ХОГГҮЙ ЦЭВЭРХЭН ШИНЭЛЦГЭЭЕ" нийтийн цэвэрлэгээний ажилд нэгдэж нийтдээ аймгийн хэмжээнд 83.5 тоон хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулав.<br><br>Аймгийн Засаг даргын А/144 дугаартай захирамж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гаргуулан “Цэвэр орчин-хоггүй Өлгий” аян зохион байгуулсан. Уг аяны хүрээнд хийх ажлуудын төлөвлөгөө гаргаж аймгийн хэмжээнд 3 удаа хатуу, эзэнгүй хог хаягдлуудыг цэвэрлэх ажлыг зохион байгуулав. Уг арга хэмжээнд нийт 736 албан хаагч, 600 иргэн, 200 сурагч нар оролцож нийтдээ 70 гаруй тонн хатуу хог хаягдлыг цэвэрлэсэн болно.<br><br>Алтай, Алтанцөгц, Дэлүүн, Буянт, Улаанхус, Өлгий сумууд болон Цагааннуур тосгоны байгаль хамгаалагчид “ЭКО”-клубийн сурагч, багш нартай хамтран “Хоггүй сум Цэвэр орчин” сарын аян зохион байгуулж, хог хаягдлыг цэвэрлэх ажилд байгууллага, ард иргэдийг оролцуулан цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж уг аян хугацаанд нийт 1351 хүн оролцож, 289 тонн хог цэвэрлүүлж, нэгдсэн хогийн цэгт буулгах ажилд гүйцэтгүүлэв.<br><br>Толбо нуурт амралт зугаалгаар ирсэн ард иргэдэд хог хаяхгүй байх, цэвэр орчинд амьдрах талаар тус сумыг хариуцсан байгаль хамгаалагч нар зөвлөгөө өгч, хяналт тавьж, Толбо нуурын эрэг болон хар зам дагуу байрлуулсан хогийн савын хогийг ачиж цэвэрлэх ажлыг Толбо сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулав.<br><br>Аймгийн Засаг даргын 2022.06.03-ны өдрийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | А/377 дугаар захирамжийн дагуу “Хоггүй-цэмцгэр-Өлгий аян зохион байгуулж Өлгий сумын 1, 2, 3, 4, 5, 6, 8, 9, 10, 11, 12, 13 дугаар багуудын нутаг дэвсгэрийн уулын энгэрт удаан жил хуримтлагдсан хог хаягдал, багийн жалга, хар зам, үерийн далан, шуудуу, айл өрхийн дунд хаясан эзэнгүй хогуудыг хүмүүсийн хүч, техник хэрэгслээр цэвэрлэж нийтдээ 200 гаруй тонн хог хаягдлыг нэгдсэн хогийн цэгт буулгах ажлыг зохин байгуулав. | |
| 5.4 | Аймгийн хэмжээнд Аюултай хог хаягдлын тооллогыг зохион байгуулах | - | Аюултай хог хаягдлын тооллого зохион байгуулсан эсэх | 2014 оны тооллогонд аймгийн хэмжээгээр 8 ААН, лаборатортай сургуулиуд хамрагдсан байна | Аюултай хог хаягдлын тооллого зохион байгуулж, дүнг нэгтгэн БОАЖЯамд тайланг хүргүүлж ажилласан байна | Аюултай хог хаягдлын тооллогыг аймгийн хэмжээгээр зохион байгуулж аюултай хог хаягдлын эх үүсвэрийн тооллогыг 3 дугаар хүснэгт, устгах шаардлагатай химийн бодисын сав баглаа боодлын тооллогыг 2 дугаар хүснэгт , устгах шаардлагатай химийн бодисын тооллогыг 1 дүгээр хүснэгтийн дагуу тус тус хугацаанд хийж дүнг нэгтгэж БОАЖЯаман хүргүүлэв.<br><br>Өлгий сумын Нэгдсэн эмнэлэг, Суат ХХК-ны лаборатор, 1,2,3,4,5 дугаар ЕБСургууль, Эмпати сургууль болон Толбо, Алтанцөгц, Улаанхус, Ногооннуур, Цэнгэл, Булган, Баяннуур сумуудын ЕБСургуулиуудад удаан жил хадгалагдсан ашиглах боломжгүй, устгах шаардлагатай нийт 288.49 кг химийн бодисуудыг Улаанбаатар хотоод аюултай хог хаягдал устгадаг Элемент | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ХХК-д гэрээ байгуулж, гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна. | |
| 5.5 | Дахин боловсруулах хог хаягдлаа цуглуулж, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх арга хэмжээ зохион байгуулах | | Цуглуулсан хог хаягдлын хэмжээ. | Хог хаягдлуудыг цуглуулж хотын дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх үйл ажиллагаа явуулдаг " Музды-тау" ХХКомпани ажилыг дэмжиж аж ахуйн нэгж, байгууллага, сургууль, цэцэрлэгээс өдөр тутамд гарч байгаа дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг цуглуулж өгөх давхир цуглуулахад туслалцаа үзүүлж 2021 онд 2 тоон хог хаягдал цуглуулсан байна. | Орон нутгийн хэмжээнд дахин боловсруулах нэгээс дээш тоон хог хаягдлаа цуглуулж, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн байна. | БОАЖЯамнаас өгсөн хог преслэгчийг ХТАлбанд хүлээлгэж өгч дахин боловсруулах боломжтой шил, лааз, хуванцрын хаягдлуудыг цуглуулж, ангилан ялгаж, преслэн Улаанбаатар хотод хог хаягдал дахин боловсруулдаг үйлдвэрүүдэд хүргүүлэхээр үйл ажиллагаа явуулж байгаа юм. Иймд Өлгий сумын төвийн аж ахуйн нэгж, ард иргэдэд хог хаягдлыг эргэлтэнд оруулах зорилгоор “Холивол хог, ангилбал баялаг” сэдвийн дагуу Өлгий сумын 13 багийн нийгмийн ажилтан, иргэд болон аж ахуйн нэгжийн дунд дахин боловсруулах боломжтой хог хаягдал болох шил, хуванцар, лааз цуглуулах уралдааныг зохион байгуулж 24 портер дахивар цуглуулж хотод ачуулах үйл ажиллагаа явагдаж байна.<br><br>Швейцар Улсын төрийн бус байгууллагын санхүүжилтээр Улаанхус сумын Хөх хөтөл багийн төвд хог хаягдлыг преслэгч машин болон, шил нунтаглах үйлдвэрүүдийг оруулж, ашиглалтад оруулахаар бэлэн болсон байна.<br>Манай аймгийн Өлгий сумын 9 дүгээр багын нутаг дэвсгэрт Сандитис ХХК Эрүүл мэндийн яамны 505 тоот тушаал | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | стандартын дагуу эмнэлгийн аюултай хог хаягдлыг устгах байгууламжийн барилга баригдаж Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулах шатанд явж байгаа болно. Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны Улсын байцаагч нар тус шинээр үйл ажиллагаа явуулахаар эмнэлгийн аюултай хог хаягдлын устгалын зориулалттай барилга байгууламжийн орчны эрүүл ахуйн нөхцөл шаардлага, ажиллагсдад тавих шаардлага, тусгай хог хаягдлын тээвэрлэлтийн шаардлага тавьж мэргэжил арга зүйн чиглэл өгч үйл ажиллагаа явуулахдаа аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, үйлчилгээний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор Баян Өлгий аймгийн МХГ-ын улсын байцаагчийн 04-03-022/65 тоот зөвлөмж өгч ажилласан байна. | |
| **6.** | **Зорилго:6** Газрын хэвлийн талаар төрөөс баримтлах бодлого | | | | | | |
| 6.1 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэх | | нөхөн сэргээлтийн ажлыг хийлгүүлэх эсэх | 2021 онд аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны улмаас эвдэрсэн 4.6 га газарт 4.000.000 төгрөгөөр техникийн нөхөн сэргээлт хийгдсэн | Эвдэрсэн газруудыг нөхөн сэргээлт хийлгэх ажлыг зохион байгуулж, тайлан мэдээг холбогдох газарт хүргүүлсэн байна | 2022 оны байдлаар Алтанцөгц сумд түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан 0,5 га газарт “Голден хаммер” ХХК 500.000 төгрөгөөр, “Өнгөт маргад” ХХК 0,7 га газарт 1 сая төгрөгөөр техникийн нөхөн сэргээлт, Улаанхус сумд түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны улмаас эвдэрсэн 2,2 га газарт 3 сая төгрөгөөр “Жол” ХХК, Бугат сумд түгээмэл тархацтай ашигт | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | малтмал ашигласны улмаас эвдэрсэн 2,2 га газарт 13 сая төгрөгөөр “Нуурт көл” ХХК нь биологийн болон техникийн нөхөн сэргээлтийн ажлыг тус тус хийж гүйцэтгэлээ.<br>2022 оны жилийн эцсийн байдалаар түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосны улмаас эвдэрсэн 5,4 га газарт 17.500.000 төгрөгөөр техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдлээ. | |
| 6.2 | Газар нутгийн орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан тухай шийдвэрээ, холбогдох мэдээллийн хамт БОАЖ-ын яам хүргүүлэн ажиллах | | Орон нутгийн тусгай хамгаалалтад авах эсэх | 2021 онд 200.000 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авхуулж ажиллаа | Орон нутгийн тусгай хамгаалалтад | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 83 дугаар тогтоолоор Толбо сумын нутагт орших Толбо нуурыг байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгал, амралт, аялал жуулчлалын ач холбогдол бүхий газар нутгийг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах зорилготой нуурын эргэн тойрны 19024 га газрыг 20 жилийн хугацаатай, аймгийн ИТХ-ын 46 дугаар тогтоолоор аялал жуулчлалын түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах зорилгоор аялал жуулчлалын нөөц газрын анилалаар Бугат сумын Өнчин толгой 71.94 га, Алтанцөгц сумын Цамбгарав уул 90.7 га, Улаанхус сумын Тахилгат толгой 1.95 га талбайтай газруудыг тус тус 20 жилийн хугацаатай тусгай хэрэгцээнд байлгахаар баталж, холбогдох материалыг Ашигт малтмалын газарт хүргүүлэн ажиллаа. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.3 | Хандлагаа өөрчилье" уриа бүхий "Ногоон паспорт" аяныг ерөнхий боловсролын сургуулиудыг хамруулан хэрэгжүүлэх | | ЕБС-ын сурагчидад ногоон паспорт олгосон тоо | Сургалт 1 удаа, сурталчилгаа ны ажлыг ногоон паспорт эзэмшигч эко клуын сурагчдын нэгдсэн группт, БОАЖГ-ын фейсбук хаягаар сурталчилан ажиллав. | Эко клубуудтай хамтран сургалт, сурталчилгаа ны ажлыг 2 удаа зохион байгуулна. | Насан туршийн боловсролын төвтэй хамтран сумдын ЕБС-ийн 1800 гаруй эко клубуудын сурагчдын дунд "ЭХ ДЭЛХИЙГЭЭ ХАЙРЛАЯ" аян зохион байгуулж, аяны хүрээнд байгаль орчныг хайрлан хамгаалах чиглэлээр сургалт, "Усны үнэ цэнэ" гар зургийн уралдаан, танин мэдэхүйн АХА тэмцээнүүдийг зохион байгууллаа. | 95 |
| 6.4 | Газрын тухай хууль, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын нутгийн тухай хууль тогтоомжийг орон нутгийн радио, телевизээр сурталчилан ажиллах | | Сурталчилгаан ы ажил зохион байгуулах эсэх | Орон нутгийн телевизээр 1 удаа ярилцлага, орон нутгийн радиогоор 3 удаа мэдээ өгч сурталчилсан , мөн байгууллагын фэйсбүүк цахим хуудсанд 5 удаагийн мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлэг түгээж ажилласан. | 4-аас доошгүй удаа сурталчилгаа ны ажил зохион байгуулсан байна | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг байгууллагын веб сайт болон фейсбуук цахим хуудсанд байршуулж, түгээж байна. Хууль сурталчлах өдөрт газрын тухай хууль, ТТАМ-ын тухай хуулиудыг хэвлэж 100 гаруй иргэнд тарааж орон нутгийн хэвлэл мэдээлэлээр хоёр удаа сурталчлан ажиллав. | 90. |
